



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/27

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтооолор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүн нуур ХХК "Зочин" дэн буудлын 13/104, Бамх ХХК "Да хүрээ" дэн буудлын 13/183, Иргэн Ч.Отгонтуяа "Голден трий" дэн буудлын 15/074, Батбадруун ХХК "Бадруун" дэн буудлын 14/85 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсууд/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАТСҮХ



1150500101

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 03 сарын 20-  
ны өдрийн A/27 дугаар тушаалын  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.03.20

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Гүн нуур ХХК	5060508	Д.Лхагвадорж	ЧД-ийн 14-р хороо Хайлаастын 12-200
2	Бамх ХХК	2848058	Да хүрээ	БГД-ийн 16-р хороо, Орхоны 11-1а
3	Иргэн Ч.Отгонтuya	ТИ88061800	Дэн буудал	ЧД-ийн 5-р хороо их тойруу 11/1
4	Батбадруун ХХК	5026776	Бадруун	СБД-ийн 13-р хороо Рашааны 8-504

--ooOoo--